

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн Хөгжлийн Банк
МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
ЭХЯ	Эрчим Хүчний Яам
ТУХ	Төслийн Удирдах Хороо
ТХН	Төслийн Хэрэгжүүлэх Нэгж



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Б. СУГАР ТАНАА

2020.05.04 № 06/1480
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Б.Сугар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчид Шилэн дансны тухай хуулийг дагаж мөрдөх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 25-наас 2020 оны 04 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Далайван Аудит ХХК-ийн захирал Ц.Жигдэн хянан удирдаж, чанарын хяналтын менежер М.Болормаа, аудитор Ж.Жаргалсүрэн нар хэрэгжүүлэв.

“Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. Далайван Аудит ХХК нь 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 30 тоот албан бичгээр төслийн нэгжийн санхүүгийн тайланг хүлээн авч аудитын ажлыг эхлүүлсэн.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

МУЗГ, АХБ-ны хооронд 2018 оны 11 дугаар сарын 02-ны өдөр нийт 66.2 сая ам.долларын өртөгтэй “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэхэд АХБ-ны ердийн хөрөнгийн эх үүсвэрээс 40.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл олгох L3708-Мон хэлэлцээр, Уур амьсгалтын стратегийн сангаас 14.6 сая ам.долларын буцалтгүй тусламж олгох G0611-Мон хэлэлцээр, Японы Хамтарсан зээл олгох Механизмын сангаас 6.0 сая ам.долларын буцалтгүй тусламж олгох G0610-Мон хэлэлцээр тус тус байгуулагдсан. Эдгээр хэлэлцээрүүд нь 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. Төсөл хаах хугацаа 2024 оны 02 дугаар сарын 29-ны өдөр. Монгол Улсын Засгийн газраас 5.6 сая ам.долларын санхүүжилтийг Бүрэлдэхүүн 1, 2-д хамаарах татварын чөлөөлөлт хэлбэрээр олгоно.

Төсөл нь Монгол Улсын алслагдмал болон буурай хөгжилтэй бүс нутгуудад хуваарилагдсан сэргээгдэх эрчим хүчний системүүдийг өргөжүүлэх, зорилтот газруудад сэргээгдэх эрчим хүчийг бий болгох хөрөнгө оруулалтыг төлөвлөх, төсөл удирдах, цахилгаан шугам сүлжээг хянах орон нутгийн цахилгаан түгээх компаниудын чадавхийг сайжруулах дэмжлэг үзүүлэх зорилготой. Төслийн хүрээнд Увс аймгийн Өмнөговь сум, Говь- Алтай аймгийн Есөнбулаг, Завхан аймгийн Улиастай, Хөвсгөл аймгийн Мөрөн, Завхан аймгийн Тэлмэн суманд нар, салхины эрчим хүч ашиглан тухайн орон нутгийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангах эх үүсвэрүүдийг шинээр байгуулна.

Тайлант оны эцсийн байдлаар АХБ-ны зээлийн эх үүсвэрээс 0.3 сая ам.долларын зарцуулалт хийж, нийт 0.7 сая ам.долларын гэрээ байгуулсан. Японы Хамтарсан зээл олгох Механизмын сангаас олгох буцалтгүй тусламжийн эх үүсвэртэй холбоотой 1.0 сая ам.долларын гэрээ хийж, 0.1 сая ам.долларын зарцуулалт хийсэн. Уур амьсгалын стратегийн сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөс зарцуулалт гараагүй байна.

“Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн журам, зааврын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”
- Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”
- Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”.

Тайлант хугацаанд төслийн нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан заавар, аргачлалд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

Харин татвар, нийгмийн даатгалын холбогдох хуульд орсон дараах өөрчлөлтүүд нөлөөлсөн. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус төсөл нь өөрийн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй.

“Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл” нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acoulous” программ хангамж ашигладаг.

“Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

Төсөл нь төлөвлөсөн үйл ажиллагааг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх, зээлийн хөрөнгийг зорилгын хүрээнд үр ашигтай зарцуулах, хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, ил тод байдлыг хангахын тулд төслийн гүйцэтгэлийн хяналт, санхүүгийн хяналт, худалдан авах үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлдэг. АХБ болон төслийн гүйцэтгэгч байгууллагаас төслийн үйл ажиллагааны үе шат бүрт хяналт тавьж ажилладаг.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төслийн зардлын гүйцэтгэлд үндэслэн гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжилт хүлээн авдаг. Иймээс нийт зардлын дүнг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 736,769.8 мянган төгрөгөөс 14,735.4 мянган төгрөгөөр тооцон материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн үйл ажиллагаа 2019 оны 07 дугаар сард эхэлсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	586,640.6	586,640.6
Авлага	-	3,950.5	3,950.5
Бараа материал	-	1,878.3	1,878.3
Үндсэн хөрөнгө	-	49,201.6	49,201.6
Хуримтлагдсан элэгдэл	-	(3,297.1)	(3,297.1)
Биет бус хөрөнгө	-	968.0	968.0
Хуримтлагдсан элэгдэл	-	(80.6)	(80.6)
Нийт хөрөнгө	-	639,261.3	639,261.3
Хуримтлагдсан үр дүн	-	639,261.3	639,261.3
Өмнөх оны үр дүн	-	-	-
Тайлант оны үр дүн	-	639,261.3	639,261.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	-	639,261.3	639,261.3

Мөнгөн хөрөнгө: Төсөл нь тайлант оны эцэст АХБ-ны зээл болон Японы хамтарсан зээл олгох механизмын сангийн ам.долларын дансдын нийт үлдэгдэл 579,260.7 мянган төгрөг, төгрөгийн дансны үлдэгдэл 7,379.9 мянган төгрөг тайлагнасан.

Авлага: Төслийн оффисын түрээсийн барьцаа болон интернетийн барьцаа төлбөрт төлсөн 3,950.5 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан.

Бараа материал: Тайлант оны эцсийн байдлаар төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа 1,172.7 мянган төгрөгийн бичиг хэрэг, 705.6 мянган төгрөгийн хангамжийн материалын зарцуулагдаагүй үлдэгдэл тайлагнасан.

Үндсэн хөрөнгө: АХБ-ны санхүүжилтээр төслийн нэгжийн үйл ажиллагаанд зориулан худалдан авсан нийт 49,201.6 мянган төгрөгийн компьютер, тавилга эд хогшил, бусад хөрөнгийг үндсэн хөрөнгөөр, нийт 968.0 мянган төгрөгийн санхүүгийн программ хангамжийг биет бус хөрөнгөөр тус тус бүртгэсэн. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгөнд нийт 3,377.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулж зардлаар бүртгэсэн.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

“Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэхэд зориулан тайланд онд 790,800.0 мянган төгрөгийн төсвийг урсгалд зардалд зарцуулахаар батлагджээ. Хөрөнгийн зардалд төсөв батлагдаагүй.

Төсвийн орлогын гүйцэтгэл 1,355,417.3 мянган төгрөг буюу төлөвлөснөөс 564,617.3 мянган төгрөгөөр давсан байна. Энэ нь ТХН-ийг байгуулахаас өмнө Сангийн яамны Хөгжийн санхүүжилтийн газраас урьдчилан тооцож баталсан тайлант оны төсөв болон ТХН байгуулагдсанаар төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө, худалдан авалтын

төлөвлөгөөнд үндэслэн бодитойгоор тооцож татан авсан санхүүжилтийн зөрүүтэй холбоотой юм. Энэ санхүүжилтийн зөрүүг Сангийн яамны Хөгжийн санхүүжилтийн газраас хянаж баталсан.

Төсвийн урсгал зардлын гүйцэтгэл 783,864.6 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байна.

Хүснэгт 2. Төсвийн орлого

/ мянган төгрөг/

Санхүүжилтийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
АХБ-ны зээлээс санхүүжих	517,800.0	943,326.6	425,526.0	182.2
Тусламжаас санхүүжих	273,000.0	412,090.7	139,090.7	150.9
Нийт дүн	790,800.0	1,355,417.3	564,617.3	171.4

Хүснэгт 3. Төсвийн зардал

/ мянган төгрөг/

Зарцуулалтын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал зардал	790,800.0	783,864.6	6,935.4	99.1
Нийт дүн	790,800.0	783,864.6	6,935.4	99.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 3 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар санхүүгийн тайланд аливаа залруулга хийгдээгүй бөгөөд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар дор дурдсан асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

- Төсвийн тухай хуульд олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байхаар зааснаар нягтлан бодох бүртгэлээ УСНББОУС-ын дагуу бүрэн аккруэл сууриар бүртгэхтэй холбоотойгоор олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын нэгдсэн заавар, аргачлалыг Сангийн яамнаас тусгайлан гаргах хэрэгтэй байна. Уг заавар, аргачлалд төслийн нэгж нь АХБ-ны зарцуулалтын үндсэн процедур болох шууд төлбөр, урьдчилгаа төлбөр, нөхөн дүүргэлтийг аккруэль сууриар хэрхэн хүлээн зөвшөөрч бүртгэж тайлагнах, хүлээн авсан болон зарцуулсан санхүүжилтэнд гадаад валютын ханшийг хэрхэн ашиглах, төслийн санхүүжилтээр бий болсон биет болон биет бус хөрөнгийг элэгдүүлэх хугацаа болон арга, төслийн санхүүжилтээр хийгдэж байгаа барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг хэрхэн хуримтлуулан бүртгэх, хөрөнгийг төсөл дуусахад төрийн өмчид шилжүүлэх, зээл тусламжийг төслийн нягтлан бодох бүртгэлд өр төлбөрөөр тусгах эсэх, зээлийн хүүгийн өр төлбөрийг хэрхэн бүртгэх;
- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд шаардсан мэдээллийг бүрэн оруулсан эсэхийг хянах;
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө болон төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг эдийн засгийн ангиллаар нь задалж тайлагнаж байгаа эсэхийг хянах;

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл” нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 87 мэдээллийг хугацаанд нь, 2019 оны эхний хагас жилд хамаарах 29 мэдээллийг хугацаа хоцроон байршуулжээ.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд санхүүгийн тайлан бэлтгээгүй.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

“Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Шилэн дансны мэдээллийн талаар

3.1.1 Илрүүлэлт:

“Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл” нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 87 мэдээллийг хугацаанд нь, 2019 оны эхний хагас жилд хамаарах 29 мэдээллийг хугацаа хоцроон байршуулжээ.

3.1.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хууль зөрчих;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийг тогтсон хугацаанд нь бүрэн гүйцэт оруулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

“Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл” нь шилэн дансны системд 2019 оны 5 дугаар сарын 27-нд бүртгүүлсэн. Харин 2019 оны 7 дугаар сард АХБ-аас анхны санхүүжилтээ авснаар төслийн үйл ажиллагаа эхэлсэн. 2019 оны улирлын, эхний хагас жилийн мэдээллүүдийг системд бүрэн байршуулах зорилгоор 2019 оны 1-6 саруудад холбогдох 29 мэдээллийг нөхөж оруулснаас системд хугацаа хоцорсон мэдээллээр бүртгэгдсэн байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	592,469,408.15
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДЛЛГАХ ХӨРӨНГӨ	-	586,640,608.15
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	586,640,608.15
31210	Төгрөг	-	7,379,865.58
31211	Төрийн сангийн харилцах	-	7,379,865.58
31220	Гадаад валютаар	-	579,260,742.57
31223	Арилжааны банкин дахь харилцах	-	579,260,742.57
33	АВЛАГА	-	3,950,500.00
33500	Бусад авлага	-	3,950,500.00
33510	Байгууллагаас авах авлага	-	3,950,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	1,878,300.00
35400	Хангамжийн материал	-	1,878,300.00
35410	Бичиг хэргийн материал	-	1,172,700.00
35470	Бусад хангамжийн материал	-	705,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	46,791,856.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	46,791,856.75
39200	Биет хөрөнгө	-	45,904,523.45
39205	Машин, тоног төхөөрөмж	-	33,437,948.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,340,438.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	13,493,476.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(752,105.85)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	2,270,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(204,556.30)
39300	Биет бус хөрөнгө	-	887,333.30
39301	Програм хангамж	-	968,000.00
39302	Хасагдуулга	-	(80,666.70)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	-	639,261,264.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	-	639,261,264.90
51	Засгийн газрын хувь оролцоо	-	639,261,264.90
51200	Хуримтлагдсан үр дүн	-	639,261,264.90
51210	Өмнөх үеийн үр дүн	-	-
51220	Тайлант үеийн үр дүн	-	639,261,264.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	-	639,261,264.90

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	1,360,943,244.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,360,943,244.98
120	Нийтлэг татварын бус орлого	-	948,852,494.98
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	948,852,494.98
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,525,930.06
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	943,326,564.92
122	Тусламжийн орлого	-	412,090,750.00
122002	Хандив тусламж /гадаад/	-	412,090,750.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	-	736,769,837.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	736,769,837.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	731,243,907.72
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	44,190,480.67
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	-	44,190,480.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	26,558,890.00
210304	Байрны түрээс	-	26,558,890.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4,526,900.03
210401	Бичиг хэргийн материал	-	3,093,280.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	-	1,433,620.03
2107	Томилолт, зочны зардал	-	22,409,611.00
210702	Дотоод томилолтын зардал	-	22,409,611.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	629,152,258.77
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	629,024,744.17
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	127,514.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,405,767.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,028,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	3,377,767.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	5,525,930.06
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,525,930.06
213306	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,525,930.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	-	624,173,407.20
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	17,761,925.66
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	17,761,925.66
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	2,674,067.96
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	2,674,067.96
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	15,087,857.70
7	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	-	639,261,264.90

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	-	1,360,943,244.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,360,943,244.98
120	Нийтлэг татварын бус орлого	-	948,852,494.98
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	948,852,494.98
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,525,930.06
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	943,326,564.92
122	Тусламжийн орлого	-	412,090,750.00
122002	Хандив тусламж /гадаад/	-	412,090,750.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	-	739,220,870.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	739,220,870.53
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	733,694,940.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	44,190,480.67
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	-	44,190,480.67
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	-	30,272,890.00
210304	Байрны түрээс	-	30,272,890.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,641,700.03
210401	Бичиг хэрэг	-	4,971,580.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,670,120.03
2107	Томилолт, зочны зардал	-	22,409,611.00
210702	Дотоод албан томилолт	-	22,409,611.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	629,024,744.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	629,024,744.17
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,155,514.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,155,514.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	5,525,930.06
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,525,930.06
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,525,930.06
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	621,722,374.45
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	50,169,624.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	50,169,624.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	50,169,624.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	50,169,624.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(50,169,624.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
14	Бусад эх үүсвэр	-	17,761,925.66
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	17,761,925.66
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	2,674,067.96
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	-	2,674,067.96
8	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	15,087,857.70
9	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	586,640,608.15
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
100	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	586,640,608.15

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	-	-
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	639,261,264.90	639,261,264.90
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	639,261,264.90	639,261,264.90

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	790,800,000.00	783,864,564.47	6,935,435.53	99.12%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	790,800,000.00	783,864,564.47	6,935,435.53	99.12%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	790,800,000.00	783,864,564.47	6,935,435.53	99.12%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,345,000.00	44,190,480.67	154,519.33	99.65%
210201	Тэтгэврийн даатгал	44,345,000.00	44,190,480.67	154,519.33	99.65%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,605,000.00	30,272,890.00	332,110.00	98.91%
210304	Байрны түрээс	30,605,000.00	30,272,890.00	332,110.00	98.91%
2104	Хангамж, бараа материалын зардал	7,700,000.00	6,641,700.03	1,058,299.97	86.26%
210401	Бичиг хэрэг	5,750,000.00	4,971,580.00	778,420.00	86.46%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,950,000.00	1,670,120.03	279,879.97	85.65%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,000,000.00	49,201,624.00	798,376.00	98.40%
210601	Багаж, техник, хэрэгсэл	37,386,000.00	35,708,148.00	1,677,852.00	95.51%
210602	Тавилга	12,614,000.00	13,493,476.00	-879,476.00	106.97%
2107	Томилолт, зочны зардал	23,000,000.00	22,409,611.00	590,389.00	97.43%
210702	Дотоод албан томилолт	23,000,000.00	22,409,611.00	590,389.00	97.43%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	633,150,000.00	629,992,744.17	3,157,255.83	99.50%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	632,150,000.00	629,024,744.17	3,125,255.83	99.51%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	968,000.00	32,000.00	96.80%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,155,514.60	844,485.40	57.78%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,155,514.60	844,485.40	57.78%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00	0.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	790,800,000.00	1,355,417,314.92	564,617,314.92	171.40%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	517,800,000.00	943,326,564.92	425,526,564.92	182.18%
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	517,800,000.00	943,326,564.92	425,526,564.92	182.18%
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	273,000,000.00	412,090,750.00	139,090,750.00	150.95%
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	273,000,000.00	412,090,750.00	139,090,750.00	150.95%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	571,552,750.45		
6	АЖИЛЛАГСАДЫН ТОО			9	
	Удирдах ажилтан			1	
	Гүйцэтгэх ажилтан			8	

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.04.27	Аудитын нэр: “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: САГ-2020/734/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр: “Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл”	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	“Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл” нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 87 мэдээллийг хугацаанд нь, 2019 оны эхний хагас жилд хамаарах 29 мэдээллийг хугацаа хоцроон байршуулжээ.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	Б. Сугар
	Зөвлөмжийн дүн	-			

